

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БУС, ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛТЭЙ БАЙДЛЫН ТАЛААР ИРГЭДИЙН ГОМДОЛ, САНАЛ ХҮЛЭЭН АВАХ 1977 УТАСНЫ 7-Р САРЫН ТАЙЛАН

Мониторинг судалгааны товч танилцуулга

“ГЛОБ ИНТЕРНЭШНЛ” ТББ нь Авилгатай Тэмцэх Газартай /цаашид АТГ гэх/ хамтарч 2007 оны долдугаар сарын 01-ээс эхлэн 6 сарын хугацаатай “Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторингийн төслийг Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр хэрэгжүүлж эхлээд нэг сар болж байна.

АТГ-аас төрийн байгууллагуудын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, иргэдийн оролцоог хангах талаар 18 зүйл бүхий зөвлөмж бичиг боловсруулж 2007 оны дөрөвдүгээр сард төрийн байгууллагуудад хүргүүлсэн билээ.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилт ямар түвшинд байгааг тандах зорилгоор төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх байгууллагад ажиглалт, сурвалжлагын болон баримт бичгийн судалгаа хийлээ.

Мөн төслийн хүрээнд төрийн байгууллагуудаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээнд гарсан зөрчлийн талаархи гомдол саналыг хүлээн авах 1977 /энгийн ярианы тарифтай/ утсыг нээлттэй ажиллуулан ирсэн мэдээллийг судлан үзэж, тухайн байгууллагын удирдлагад АТГ-аас үйл ажиллагаандаа гаргасан зөрчилөө нэн даруй арилгах арга хэмжээ авч, эргэж мэдээллэхийг сануулсан шаардлага хүргүүлэн ажиллаж байна.

1977 утсаар 2007 оны 07 дугаар сарын 09–нөөс эхэлж, энэ оны 12 сар дуустал иргэдээс төрийн байгууллагын хүнд суртал, төрийн үйлчилгээний ил тод байдлын талаар гомдол саналыг хүлээн авч сар бүрийн 05-ын дотор иргэдээс ирсэн гомдол саналыг нэгтгэн АТГ болон өөрийн вэб сайтаараа олон нийтэд мэдээллэж байна.

2007 оны 07 дугаар сарын 09-ээс 31 хүртэлх хугацаанд 1977 утсаар иргэдээс нийт 46 гомдол, 4 саналыг авч цаг тухайд АТГ-т хүргүүллээ.

Гомдол өгсөн иргэдийн 43 нь Улаанбаатар хотоос, 3 нь хөдөө орон нутгаас холбогдож мэдээлэл өгсөн.

46 иргэний 14 нь өмнө нь тухайн байгууллага албан тушаалтанд дийлэнх хувь нь одоо хандаж байгаатай ижил зорилгоор, үлдсэн хувь нь өөр бусад зорилгоор зохих журмын дагуу нэг иргэн дунджаар 6.9 удаа очиж байсан хэдий ч тэдний 13 нь авах ёстой төрийн үйлчилгээгээ авч чадаагүй нь хангалтгүй үзүүлэлт юм. Сүүлийн жилүүдэд иргэд ихээр үйлчлүүлэх болсон газрын албад болон МЦХ-нд нийт гомдол гаргасан иргэдийн дийлэнх хувь нь хандаж байсан байна.

Байгууллагын тухай мэдээлэл

Хандсан иргэдийн 41 хувь нь улсын, 30 хувь нь аймаг, нийслэлийн, 17 хувь нь дүүрэг сумдын, 11 хувь нь баг хорооны хэмжээнд үйл ажиллагаагаа иргэдэд хүргэдэг төрийн байгууллагад хандсан байна.

Иргэдийн гомдол гаргасан төрийн байгууллагуудыг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл 26 хувь нь газрын албад, 13 хувь нь засаг даргын тамгийн газарууд, 9 хувь нь шүүхийн шийдвэр биелүүлэх газаруудад болон 9 хувь нь эрүүл мэндий байгууллагийн ажилтан, албан тушаалтанууд иргэдийг илүү чирэгдүүлж байна гэсэн мэдээлэл өгсөн. Үүнийг ирсэн гомдолууд төрийн байгууллагын үйлчлүүлдэг иргэдийн тооноос хамаарч харилцан адилгүй байна гэж хэлж болно.

Сум дүүргийн засаг даргын тамгийн газарууд, замын цагдаагын газарууд, газрын албад улсын эмнэлэг, шүүхийн шийдвэр биелүүлэх газар, аймаг нийслэл, сум дүүргүүдийн засаг даргын тамгийн газрууд иргэдийг ихээр чирэгдүүлж байна.

Албан тушаалтны тухай мэдээлэл

Утсаар өгсөн гомдол нь тухайн байгууллагыг бүхэлд нь биш төрийн байгууллагыг төлөөлж байгаа ажилтан, албан тушаалтны талаар өгч байгаа гомдол юм гэдгийг гомдол гаргасан иргэдийн 80 орчим хувь нь зөрчил гаргасан албан тушаалтны нэрийг тодорхой хэлсэн нь, үлдсэн 20 хүрэхгүй хувь нь төрийн байгуулалын тодохой хүрээний албан тушаалтнуудыг хамруулж нэрлэсэн нь харуулж байгаа.

Зөрчил гаргасан албан тушаалтнуудыг авч үзвэл мэргэжилтэн, шинжээч, байгцаагчид зэрэг төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалтан болон цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч, ахлагч зэрэг төрийн тусгай гүйцэтгэх албан тушаалтанд иргэдийн талаас илүү хувь нь гомдол гаргасан.

Төрийн байгууллагад хандсан асуудал

Утсанд хандсан иргэдийн 17 хувь нь өмч эзэмших эрхийн бичиг авах, 15 хувь нь хураалгасан буюу бусдад хууль бусаар алдсан өмчөө эрүүлж авах, 9 хувь нь аюулгүй амьдрах орчноо хангуулах асуудлаар очсон гэж хариулсан болно. Мөн иргэдийн 15 хувь нь буюу 7 иргэн тухайн төрийн байгууллагад хандаагүй ба төрийн байгууллагын албан тушаалтны зөрчил гаргаж байгааг харсан, гэрчилж чадна гэж хэлсэн.

Гомдол гаргаж байгаа үндэслэл

Иргэдийн 25 хувь нь байгууллагын үйл ажиллагааны дүрэм журам болон хуульд заасан хугацаандаа шийдвэрлэж өгөхгүй байна, 19 хувь нь байгууллагын үйл ажиллагааны чиглэлдээ хамаарах асуудлыг авч хэлцэхгүй өөрсдөө шийд гэх мэт зүйл хэлсэн, 16 хувь нь албан тушаалтнууд хүнд суртал гаргаж бүдүүлгээр доромжилж арчаагүй мэдлэггүй гэх мэтээр загнаж хөөсөн, 10 хувь нь албан тушаалтан нар өөрсдийн эрх мэдлээ ашиглаж иргэдээс үндэслэлгүй мөнгө нэхэж байна гэсэн үндэслэлээр гомдол гаргажээ.

Үүнийг төрийн байгууллагын цар хүрээгээр харьцуулбал улсны хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагууд үндэслэлгүйгээр нэмэлт төлбөр авах, хүнд суртал гаргах, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй, хүнд

суртал гаргах, хууль дүрмийн дагуу асуудлыг шийдэж өгөхгүй удах, аймаг дүүргийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагуудын хувьд хугацаанд нь шийдвэдэж өгөхгүй удах, хүнд суртал гаргах зэрэг зөрчилүүд элбэг тохиолдож байна.

Мөн үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл шүүхийн шийдвэр биелүүлэх газаруудад хууль дүрмийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байх, засаг даргын тамгийн газаруудад хувьд хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удаах, үндэслэлгүйгээр олон нэмэлт төлбөр авах, хууль дүрмийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байх, газрын албадад хувьд хугацаанд нь шийдвэрлэж өгөхгүй удаах, хууль дүрмийн дагуу асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байх, олон шат дамжлагатай байх, хүнд суртал гаргах нь албан тушаалтнуудад элбэг тохиолддог.

Тухайн байгууллагад хандаад зарцуулсан хугацаа

Утсанд хандсан иргэдээс тухайн байгууллага, албан тушаалтанд хандаад ямар хугацааг зарцуулж байгааг асуухад 8 хувь нь нэг сар болоогүй, 13 хувь нь 1-өөс 3 сар, 20 хувь нь 4-өөс 6 сар, 33 хувь нь 7 сараас нэг жил, 13 хувь нь 1-нээс 2 жил, мөн 13 хувь нь 2-оос дээш жил болсон гэж хариулсан.

Үүнийг байгууллагын цар хэмжээнд нь харьцуулбал сар болоогүй иргэдийн 67 хувь нь улс, 3 сар болоогүй иргэдийн 60 хувь нийслэл, 6 сар болоогүй иргэдийн 45 хувь нь нийслэл, нэг жил болоогүй иргэдийн 43.8 хувь нь улс, хоёр жил болоогүй иргэдийн 60 хувь нь нийслэл, хоёроос дээш жил болж байгаа иргэдийн 40 хувь нь нийслэл мөн тийм хувь нь сум дүүргүүдийн төрийн байгууллагын албан тушаалтан нар иргэдийг хохироож байна. Үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл газрын албад иргэдийн зарцуулсан хугацааны бүх түвшинд хамгийн өндөр хувьтай, үүнийг яамд, цагдаагийн байгууллага болон эрүүл мэндийн байгууллагууд удаалж байна.

Дээрхээс харахад тухайн байгууллагад хандсан иргэдийн 20 хувь нь тухайн байгууллагад хандаад 3 сар болоогүй байна гэж хариулсан нь зөвхөн хугацаа биш төрийн байгууллагыг төлөөлж байгаа албан тушаалтан нь шүүх цагдаагийн шийдвэрт нөлөөлсөн, хүнд суртал гаргах, ажилчдаа дарамтлах, хуулийн дагуу асуудлыг шийдэж өгөхгүй байх зэрэг бусад асуудлуудаар хандсан болно.

Иргэдийн саналын тухай мэдээлэл

4 иргэний 3 нь буюу 75 хувь нь АТГ-т, нэг нь Нийслэлийн Газарын Албаны албан хаагчдад хандаж зөвшөөрөлгүй барилга барьж байгаа, ашигт малтмал хууль бусаар хил давж байгаад хяналт тавих, гаалийн татвараа хил залгаа орны гаалийн татвартай уялдуулж тогтоох, төрийн албан хаагчид их хэмжээний газар эзэмшээд зогсохгүй өөрсдийн хувийн хаус барьж байгааг шалгаж өгөхийг хүссэн хүсэлт тавьсан. Мөн тэд бүгд эргэж холбоо барих утсаа өгсөн болно.